Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцины талаарх эцэг эх, асран хамгаалагчдын хандлагыг судалсан дүн

Х.Нансалмаа[1], Л.Баярмагнай[2], О.Дашпагам[3], Д.Оюунбилэг[4], Д.Даваалхам[5]*

[1]АШУҮИС, НЭМС, Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим
[2]АШУҮИС, НЭМС, Эпидемиологи, Биостатистикийн тэнхим
[3]Халдварт өвчин судлалын үндэсний төв, Дархлаажуулалтын алба
[4]АШУҮИС, Оюутны хөгжил, удирдлагын газар
[5]АШУҮИС, Нийгмийн эрүүл мэндийн сургууль
Цахим шуудан: nansalmaa.kh@mnums.edu.mn, Утас: 99980205

Түлхүүр үг:
Товлолт дархлаажуулалт
Умайн хүзүүний хавдар
Вакцины эргэлзээ

Товч утга:

Үндэслэл: Монгол улсад стандартчилсан үзүүлэлтээр умайн хүзүүний хорт хавдар нь 100,000 эмэгтэй тутамд 20.2 тохиолдол, 9.6 нас баралт байгаа нь дэлхийн болон бүсийн түвшинтэй харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Умайн хүзүүний хорт хавдрын гол үүсгэгч нь хүний папиллома вирус (ХПВ)-ийн халдвар бөгөөд халдвараас сэргийлэх арга нь ХПВ-ийн дархлаажуулалт юм. Монгол улсын Дархлаажуулалтын тухай хуульд 2023 онд нэмэлт өөрчлөлт орж, хүний папиллома вирус (ХПВ)-ийн халдварын эсрэг вакциныг 11 настай хүүхдэд заавал хийх үндэсний товлолт вакцинд орсон. ХПВ-ийн халдвар болон ХПВ-ийн халдварын эсрэг вакцины талаарх хандлага нь вакцин хийлгэх шийдвэрт чухал нөлөөтэй байдаг. Иймд шинээр нэвтрүүлж буй вакцины талаарх эцэг эх, асран хамгаалагчдын хандлага, вакцин хийлгэх шийдвэрийн талаар судлах хэрэгцээ байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болж байна. **Зорилго:** Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцины талаарх эцэг эх, асран хамгаалагчдын хандлагыг судлах. **Арга, аргачлал:** Агшингийн судалгааны загвараар, тоон аргаар мэдээллийг цуглуулж, үр дүнг SPSS-25.0 программд боловсруулсан. Судалгаанд Монгол улсын бүсийн төлөөлөл 4 аймаг, 8 сум, УБ хотын 3 дүүргээс нийт 3057 эцэг эх, асран хамгаалагч хамрагдсан. ХПВ-ийн халдварын эсрэг вакцины талаарх хандлагыг тодорхойлохдоо вакцины ач холбогдол, үр нөлөөг үнэлж, санал нийлж буй байдал, вакцин хийлгэх сэдлээр тодорхойлсон. **Үр дүн:** Судалгаанд нийт 3057 эцэг эх, асран хамгаалагч оролцсоноос хөдөө орон нутгийн иргэд 47.92 хувь, Улаанбаатар хотын иргэд 52.08 хувийг эзэлж байна. Судалгаанд оролцогчдын ихэнх (62.43) хувийг 9-11 насны хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид эзэлж байна. Судалгаанд оролцогчдын 19.85 хувь нь хүүхдээ ХПВ-ийн халдвар авах эрсдэлтэй гэж үзэж, ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь ХПВ-ийн халдвартай холбоотой хорт хавдраас урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй гэж 37.58 хувь нь үзсэн байна. Эцэг эх, асран хамгаалагчдын 13 хувь нь хүүхдээ ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийлгэнэ гэж хариулсан бөгөөд 10 хүн тутмын 8 нь эргэлзэж байна гэжээ. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийлгэхгүй байх шалтгааныг тодруулахад вакцин хийлгэсний дараа ямар нэг гаж нөлөө гарахаас санаа зовж байна, вакцины чанар болон алсын үр дагаварт санаа зовж, эргэлзэж байна гэсэн хариулт зонхилсон байна. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийлгэх шийдвэр гаргахад вакцины талаарх нотолгоонд суурилсан мэдээлэл (48.9 хувь) болон эрүүл мэндийн ажилтны зөвлөгөө, мэдээлэл (40.63 хувь) чухал гэж эцэг эх, асран хамгаалагчид үзэж байна. ХПВ-ийн халдварын эсрэг вакцины талаарх хандлага хүйсийн хувьд ялгаагүй бол байршил, насны хувьд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна. **Дүгнэлт:** ХПВ-ийн халдварын эсрэг вакцинаас татгалзах болон эргэлзэхэд нөлөөлж буй асуудлыг шийдвэрлэхэд вакцины аюулгүй байдал, гаж нөлөө, үр дүнтэй байдлын талаарх нотолгоонд суурилсан мэдээллийг эцэг, эх асран хамгаалагчид өгөх, үүнд эрүүл мэндийн мэргэжилтнүүд хамгийн чухал, найдвартай эх сурвалж болохыг тодорхойллоо.

Үндэслэл: Умайн хүзүүний хорт хавдар (УХХХ) нь эмэгтэйчүүдийн дунд түгээмэл тохиолддог хорт хавдрын 4-рт ордог. Дэлхийн хэмжээнд 2022 оны байдлаар УХХХ-ын 660000 шинэ тохиолдол, 350000 нас баралт бүртгэгдсэн бөгөөд стандартчилсан үзүүлэлтээр жилд дунджаар 100000 эмэгтэйд 13.3 тохиолдол, 100000 эмэгтэйд 7.2 нас баралт бүртгэгдсэн байна.[1] Харин Монгол улсад стандартчилсан үзүүлэлтээр умайн хүзүүний хорт хавдар нь 100,000 эмэгтэй тутамд 20.2 тохиолдол, 9.6 нас баралт байгаа нь дэлхийн болон бүсийн түвшинтэй харьцуулахад өндөр үзүүлэлт юм.[2] Умайн хүзүүний хорт хавдрын гол үүсгэгч нь хүний папиллома вирус (ХПВ)-ийн халдвар юм.[3] ХПВ-ын халдвар нь бэлгийн хавьтал болон арьс салстаар дамждаг бөгөөд ХПВ-ын халдварын 90 хувь нь 1-2 жилийн хугацаанд өөрөө аяндаа устдаг, харин 10 орчим хувь нь биед удаан хугацаагаар хадгалагдаж, архаг хэлбэрт шилжиж ХПВ-ийн шалтгаант хорт хавдар болон өвчнүүдийг үүсгэдэг байна. Үүнд: Толгой хүзүү, ам залгиурын хорт хавдар, умайн хүзүүний хорт хавдар, умайн хүзүүний хорт хавдрын урьдал, эр, эм бэлэг эрхтний хорт хавдар, бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдар, бэлгийн үү тус тус хамрагддаг байна.[4] ХПВ-ийн дархлаажуулалт нь ХПВ-ийн халдвараас сэргийлэх хамгийн үр дүнтэй арга юм.[5] Одоогоор дэлхийн 136 улс ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг дархлаажуулалтын хөтөлбөртөө оруулсан байна.[6] Монгол улсын Дархлаажуулалтын тухай хуульд 2023 онд нэмэлт өөрчлөлт орж, хүний папиллома вирус (ХПВ)-ийн халдварын эсрэг вакциныг 11 настай хүүхдэд заавал хийх үндэсний товлолт вакцинд орсон.[7] Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас 2030 он гэхэд ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалтад 15-аас доош насны охидын 90 хувийг хамруулах зорилт тавьсан.[8] Монгол улс 2012 онд ДЭМБ-ийн зөвлөмжөөр анх удаа ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг нэвтрүүлсэн боловч үргүйдэлд хүргэдэг гэх ташаа мэдээлэл олон нийтийн сүлжээнд тархаж, үүний улмаас дархлаажуулалт зогсож байсан. Тухайн үед вакцинд хамрагдаж байсан охидыг тав жилийн дараа вакцин хийлгээгүй охидтой харьцуулахад вакцин хийлгээгүй 10 охид тутмын нэг нь хавдар үүсгэх өндөр эрсдэл бүхий 16 дугаар хэв шинж илэрч, вакцин хийлгэсэн хүүхдүүд үүнээс 10 дахин бага үзүүлэлттэй тодорхойлогдсон байдаг.[9] Мөн ХПВ-ийн халдварын эсрэг вакцины нөлөөлөл, зардал үр дүнгийн судалгаагаар зардал багатай, хамгийн үр дүнтэй стратегийн загвар нь 11 настай хүүхдүүдийг хамруулах гэж дүгнэсэн байна.[10]

ХПВ-ийн халдвар болон ХПВ-ийн халдварын эсрэг вакцины талаарх ойлголт, хандлага нь вакцин хийлгэх шийдвэрт чухал нөлөөтэй байдаг.[11] Иймд шинээр нэвтрүүлж буй вакцины талаарх эцэг эх, асран хамгаалагчдын хандлага, вакцин хийлгэх шийдвэрийн талаар судлах хэрэгцээ, шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болж байна.

Зорилго: Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцины талаарх эцэг эх, асран хамгаалагчдын хандлагыг судлах.

Арга, аргачлал: Судалгааг аналитик судалгааны нэг агшингийн загварыг ашиглан, асуумжийн аргаар мэдээллийг 2024 оны 5-6 сард цуглуулсан. АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2024/3-06 шийдвэрээр судалгааны ажлын ёс зөвшөөрлийг авсан. Судалгаанд Монгол улсын 4 бүсийн төлөөлөл Баян-Өлгий, Өмнөговь, Архангай, Дорнод аймаг, УБ хотын Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн 15-аас доош насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч нар санамсаргүй түүвэрлэлтийн аргаар хамрагдсан. ХПВ-ийн халдварын эсрэг вакцины талаарх хандлагыг тодорхойлохдоо вакцины ач холбогдол, үр нөлөөг үнэлж, санал нийлж буй байдал, вакцин хийлгэх сэдлээр тодорхойлсон. Судалгааны үр дүнг SPSS-25.0 программ дээр боловсруулалт хийж, P утга 0.05-аас бага байх тохиолдолд ялгааг статистик үнэн магадлалтай гэж үзсэн.

Үр дүн: Судалгаанд нийт 3057 эцэг эх, асран хамгаалагч оролцсоноос хөдөө орон нутгийн иргэд 47.92 хувь, Улаанбаатар хотын иргэд 52.08 хувийг эзэлж байна. Судалгаанд оролцогч эцэг эх, асран хамгаалагчид ихэвчлэн 9-11 насны 1 хүүхэдтэй ба хамгийн их нь 3 хүүхэдтэй байсан. Хүүхдийн хүйсийн хувьд 49.71 хувь нь эрэгтэй, 50.29 хувь нь эмэгтэй, 9-11 насны хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид судалгаанд оролцогчдын ихэнх (62.43) хувийг эзэлж байна.

Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцины талаарх хандлагыг тодорхойлохдоо вакцины үр дүнг хэрхэн үнэлж байна, вакцин хийлгэхгүй бол хожим үүсэх эрсдэл, аюулыг хэрхэн үнэлж байна, охид болон хөвгүүдэд вакцин хийлгэхтэй санал нийлж буй байдал, өөрийн хүүхдэд вакцин хийлгэх эсэх асуултуудаар үнэллээ.

Судалгаанд оролцогчдын 19.85 хувь нь өөрийн хүүхдээ ХПВ-ийн халдвар авах эрсдэлтэй гэж үзэж байгаа бол ихэнх эцэг эхчүүд ХПВ-ийн халдвар авах эрсдэл бага гэж бодож байна. Харин ирээдүйд хүүхэд нь ХПВ-ийн халдвар авбал аюултай гэж 2 эцэг эх тутмын 1 нь үзэж байгаа нь тодорхойлогдлоо (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдагсдын ХПВ-ийн халдварын эрсдэлийн талаарх үзэл бодлыг судалсан дүн

	Үзүүлэлт	Тоо	Хувь
Та хүүхдээ ХПВ-ийн халдвар авах эрсдэлтэй гэж бодож байна уу?			
1	Маш их эрсдэлтэй	244	7.9
2	Их эрсдэлтэй	363	11.8
3	Дунд зэрэг эрсдэлтэй	418	13.6
4	Бага зэрэг эрсдэлтэй	553	18.0
5	Огт эрсдэлгүй	595	19.4
6	Мэдэхгүй байна	884	28.9
Таны хүүхэд хожим ХПВ-ийн халдвар авбал аюултай гэж бодож байна уу?			
1	Маш их аюултай	648	21.2
2	Аюултай	1,114	36.4
3	Зарим талаар аюултай	335	10.9
4	Бага зэрэг аюултай	203	6.6
5	Огт аюулгүй	144	4.7
6	Мэдэхгүй байна	613	20.0

Судалгаанд оролцогчид ХПВ-ийн халдварын эрсэг вакцин нь ХПВ-ийн халдвартай холбоотой хорт хавдраас урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй гэдэгтэй 37.58 хувь нь санал нийлж байгаа бол вакцин хийлгэхгүй бол хожим эрсдэл их байх болно гэж 2 хүн тутмын 1 нь үзэж байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдагсдын ХПВ-ийн халдварын эрсэг вакцины үр дүнгийн талаарх үзэл бодлыг судалсан дүн


	Үзүүлэлт	Тоо	Хувь
ХПВ-ийн халдварын эрсэг вакцин нь ХПВ-ийн халдвартай холбоотой хорт хавдраас урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй юу?			
1	Маш их үр дүнтэй	340	11.1
2	Үр дүнтэй	809	26.4
3	Зарим талаар үр дүнтэй	441	14.4
4	Бага зэрэг үр дүнтэй	260	8.5
5	Огт үр дүнгүй	351	11.4
6	Мэдэхгүй	856	28.0
ХПВ-ийн халдварын эрсэг вакцин хийлгэхгүй бол хожим эрсдэлтэй гэж бодож байна уу?			
1	Маш их эрсдэлтэй	441	14.4
2	Их эрсдэлтэй	960	31.4
3	Дунд зэрэг эрсдэлтэй	471	15.4
4	Бага зэрэг эрсдэлтэй	274	8.9
5	Огт эрсдэлгүй	189	6.1
6	Мэдэхгүй байна	722	23.6

ХПВ-ийн халдварын эрсэг вакциныг охид болон хөвгүүдэд хийх нь зөв гэдгийг Эцэг эх, асран хамгаалагчдын 22.4 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бөгөөд ХПВ-ийн халдварын эрсэг вакциныг охид болон хөвгүүдэд хийлгэхтэй санал нийлэх байдал нь хүйсийн хувьд ялгаагүй байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. ХПВ-ийн халдварын эрсэг вакциныг хүүхдүүдэд хийлгэх талаарх санал бодлыг судалсан дүн (хүйсээр)


	ХПВ-ийн халдварын эрсэг вакцин хийлгэх нь зөв	Охидод	Хөвгүүдэд
		Тоо (хувь)	Тоо (хувь)
1	Маш их санал нийлнэ	327 (10.7)	285 (9.3)
2	Санал нийлнэ	894 (29.2)	799 (26.1)
3	Зарим талаар санал нийлнэ	466 (15.2)	482 (15.7)
4	Бага зэрэг санал нийлнэ	314 (10.2)	358 (11.7)
5	Огт санал нийлэхгүй	370 (12.1)	410 (13.4)
6	Мэдэхгүй байна	686 (22.4)	686 (22.4)

Судалгаанд оролцогч 10 хүн тутмын 1 нь л ХПВ-ийн халдварын эрсэг вакцин хүүхдэдээ хийлгэх талаар хэн нэгэнтэй ярилцаж байсан, 44.72 хувь нь вакцин хийлгэх талаар бодож байгаагүй байна. Эцэг эх, асран хамгаалагчдын 13 хувь нь хүүхдэдээ ХПВ-ийн халдварын эрсэг вакцин хийлгэнэ, 8 хувь нь хийлгэхгүй гэж хариулсан бөгөөд ихэнх эцэг эх, асран хамгаалагчид эргэлзэж байна (Зураг 1).



Зураг 1. Судалгаанд хамрагдагсдын ХПВ-ийн халдварын эрсэг вакцин хийлгэх шийдвэрийг судалсан дүн

ХПВ-ийн халдварын эрсэг вакцин хийлгэхгүй байх шалтгааныг тодруулахад вакцин хийлгэсний дараа ямар нэг гаж нөлөө гарахаас санаа зовж байна гэсэн хариулт хамгийн их хувийг эзэлж, үүний дараа вакцины чанар болон алсын үр дагаварт санаа зовж, эргэлзэж байна гэсэн хариулт орж байна (Зураг 2).



Зураг 2. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хүүхдэдээ хийлгэхээс татгалзах болон эргэлзэж байгаа шалтгааныг тодорхойлсон дүн /хувиар/

ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийлгэх шийдвэр гаргахад вакцины талаарх нотолгоонд суурилсан мэдээлэл (48.09%) болон эрүүл мэндийн ажилтны зөвлөгөө, мэдээлэл (40.63%) хамгийн чухал гэж эцэг эх, асран хамгаалагчид үзэж байна.

ХПВ-ийн халдварын эсрэг вакцинд эцэг эхчүүдийн 77.8 хувь нь сөрөг хандлагатай бөгөөд вакцины талаарх хандлага хүйсийн хувьд ялгаагүй байна. Харин ХПВ-ийн халдварын эсрэг вакцины хандлага нь байршил, насны хувьд статистик ач холбогдол бүхий ялгаатай буюу байршлын хувьд хөдөө, орон нутгийн иргэд хотын иргэдтэй харьцуулахад илүү эерэг хандлагатай бол насны хувьд залуучууд бусад насны бүлгүүдтэй харьцуулахад сөрөг хандлагатай байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Судалгаанд хамрагдагсдын ХПВ-ийн халдвар болон вакцины талаарх хандлагыг судалсан дүн (хүйс, байршил, насаар)

Үзүүлэлт		ХПВ-ийн халдварын эсрэг вакцины талаарх хандлага				P утга
		Эерэг		Сөрөг		
		Тоо	Хувь	Тоо	Хувь	
Хүйс	Эрэгтэй	148	20.67	568	79.33	0.103
	Эмэгтэй	513	23.62	1659	76.38	
Байршил	Хот	306	19.22	1,286	80.78	0.001*
	Хөдөө	368	25.12	1,097	74.88	
Нас	25 хүртэл	17	19.1	72	80.9	0.001*
	26-35 нас	164	21.84	587	78.16	
	36-45 нас	269	22.68	917	77.32	
	46-55 нас	126	29.58	300	70.42	
	56+ нас	40	26.14	113	73.86	

Хэлцэмж: Бид ХПВ-ийн халдварын эсрэг вакцины талаарх эцэг эх, асран хамгаалагчдын хандлага, вакцин хийлгэх шийдвэр, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар судаллаа. Судалгаанд нийт 3057 эцэг эх, асран хамгаалагч хамрагдсан бөгөөд ХПВ-ийн халдвар, халдварын эсрэг вакцинд эцэг эх, асран хамгаалагчдын ихэнх нь сөрөг хандлагатай бөгөөд 10 хүн тутмын 8 нь вакцин хийлгэх талаар эргэлзэж байгаа нь тодорхойлогдлоо. Бид өөрсдийн үр дүнг бусад улс болон ижил төстэй судалгааны ажлын үр дүнтэй харьцуулан судаллаа.

Манай улстай ижил буюу ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг хараахан нэвтрүүлж эхлээгүй байгаа Бахрейн улсад (2019) хийгдсэн судалгаагаар судалгаанд оролцогчдын дийлэнх нь (76%) нь санал болгосон тохиолдолд вакцин хийлгэхэд бэлэн бөгөөд 84.8 хувь нь хоёр хүйсийг вакцинжуулах ёстой гэж үзсэн байна.[12] Манай улсын хувьд эцэг эх, асран хамгаалагчдын 13 хувь нь л хүүхдэдээ ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийлгэнэ, хоёр хүйсийг вакцинжуулах нь зөв гэдэгтэй 37.6 хувь санал нийлж байгаа нь вакцины талаар сөрөг хандлага, эргэлзээ их байгааг илтгэж байна. Харин ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг хийлгэх бэлэн байдлаас үл хамаарч гаж нөлөөний талаар санаа зовох асуудал нийтлэг (Бахрейн 48.5%, Монгол 30.45%) байна. Эцэг эхчүүдийн ХПВ-ийн халдварын эсрэг вакцины талаарх мэдээлэл дутмаг байх, вакцины аюулгүй байдалд санаа зовох нь вакцин хийлгэхгүй байх гол шалтгаан болдог байна.[13]

Этиоп улсын Дебре Маркос хот дахь (2021) ХПВ-ийн халдварын эсрэг вакцинд хамрагдах зорилтод бүлгийн охидтой 601 ээжийг хамруулсан судалгаагаар 77.4 хувь нь ХПВ-ийн халдварын эсрэг вакцины талаар эерэг хандлагатай байсан байна.[14] Энэхүү судалгаа нь судалгааны аргачлал болон зорилтот бүлгийн насны хүүхдүүдийн ээжүүдийг хамруулсан нь манай судалгаатай төстэй юм. Бидний судалгаагаар 77.8 хувь нь ХПВ-ийн халдварын эсрэг вакцины талаар сөрөг хандлагатай байна. Уг судалгаагаар судалгаанд оролцогчдын 45.1 хувь өөрийн охидыг ХПВ-ийн

халдвараар өвчлөх эрсдэлтэй гэж үзсэн бол бидний судалгаагаар 20 хувь нь эрдэлтэй гэж үзсэн байна. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь үр дүнтэй гэж 74.4 хувь нь үзсэн бол бидний судалгаагаар 38 хувь нь үр дүнтэй гэж үзсэн байна. Энэхүү ялгаатай үзүүлэлт нь Этиоп улсын хувьд сургуульд суурилсан байдлаар ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалтыг нэвтрүүлээд 3 жилийн дараа уг судалгаа хийгдсэнтэй холбоотой байж болох юм.

Usman Ayub Awan[15] (2023) нарын судалгаагаар өсвөр насны хүүхдүүдэд ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийх нь зөв гэж 66 хувь нь санал нийлж байвал манай судалгаанд 37.6 хувь байгаа нь бага үзүүлэлт байна. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь ХПВ-ийн халдвараас үүдэлтэй хавдраас урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй гэж 37.58 хувь нь санал нийлсэн нь Йорданд хийсэн 386 эцэг, эх хамруулсан судалгааны[16] үр дүнтэй (35.6%) ижил байна. Йордан улсын хувьд ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг товлолын дархлаажуулалтын хөтөлбөртөө оруулаагүй байна. Вакцины талаарх сөрөг хандлага нь гол төлөв гаж нөлөөнөөс айх, үр дүнтэй гэдэгт нь итгэлгүй байх, шашин шүтлэг, соёлын шалтгаантай байна.[12] Манай улсын хувьд вакцины гаж нөлөө, үр дүнд итгэхгүй байхаас гадна энэ вакциныг улс орон даяар нэвтрүүлээгүй шинэ вакцин гэдэг шалтгаан вакцинаас татгалзах, эргэлзэхэд нөлөөлж байна.

Дүгнэлт: ХПВ-ийн халдварын эсрэг вакцинаас татгалзах болон эргэлзэхэд нөлөөлж буй асуудлыг шийдвэрлэхэд вакцины аюулгүй байдал, гаж нөлөө, үр дүнтэй байдлын талаарх нотолгоонд суурилсан мэдээллийг эцэг, эх асран хамгаалагчид өгөх, үүнд эрүүл мэндийн мэргэжилтнүүд хамгийн чухал, найдвартай эх сурвалж болохыг тодорхойллоо.

Ном зүй:

1. *Bray F, Laversanne M, Sung H, et al. Global cancer statistics 2022: Globocan estimates of incidence and mortality worldwide for 36 cancers in 185 countries. CA: A Cancer Journal for Clinicians. 2024;74(3):229-263. doi:10.3322/caac.21834*
2. *Cancer Today. Global Cancer Observatory. Accessed November 10, 2024. https://gco.iarc.fr/today/en/dataviz/bars?mode=population&cancers=23&types=1&populations=496_900_935.*
3. *de Freitas A, Gomes Leitao M, Coimbra E. Prospects of molecularly-targeted therapies for cervical cancer treatment. Current Drug Targets. 2015;16(1):77-91. doi:10.2174/138945011666614 1205150942*
4. *Эрүүл мэндийн яам.Умайн хүзүүний хорт хавдрын цогц хяналтын заавар. Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/641-р тушаал.*
5. *Brotherton JM, Gertig DM, May C, Chappell G, Saville M. HPV vaccine impact in Australian women: Ready for an hpv-based screening program. Medical Journal of Australia. 2016;204(5):184-184. doi:10.5694/mja15.01038*
6. *Life-saving HPV vaccine introduced nationwide into routine immunization schedule to prevent cervical cancer in Cambodia. UNICEF. Accessed November 23, 2024. https://www.unicef.org/cambodia/press-releases/life-saving-hpv-vaccine-introduced-nationwide routine-immunization-schedule-prevent.*
7. *Монгол Улс. Төрийн мэдээлэл. Дархлаажуулалтын тухай хууль. Улаанбаатар. Засгийн газрын дэргэдэх хэвлэх үйлдвэр. 2000.*
8. *Global strategy to accelerate the elimination of cervical cancer as a public health problem. World Health Organization. Accessed October 15, 2020. https://www.who.int/publications-detail-redirect/9789240014107.*
9. *Batmunkh T, von Mollendorf C, Tulgaa K, et al. HPV genoprevalence and HPV knowledge in young women in Mongolia, five years following a pilot 4vhpv vaccination campaign. Papillomavirus Research. 2019;8:100175. doi:10.1016/j.pvr.2019.100175*
10. *Luvsan M-E, Vodicka E, Jugder U, et al. The potential cost-effectiveness of HPV vaccination among girls in Mongolia. Vaccine: X. 2022;11:100161. doi:10.1016/j.jvacx.2022.100161*
11. *Brotherton, J.M.L.; Bloem, P.N. Population-based HPV vaccination programmes are safe and effective: 2017 update and the impetus for achieving better global coverage. Best Pract. Res. Clin. Obstet. Gynaecol. 2018, 47, 42–58.*
12. *Husain Y, Alalwan A, Al- Musawi Z, et al. Knowledge towards human papilloma virus (HPV) infection and attitude towards its vaccine in the Kingdom of Bahrain: crosssectional study. BMJ Open 2019;9:e031017. doi:10.1136/ bmjopen-2019-031017*
13. *Netfa F, Tashani M, Booy R, King C, Rashid H, Skinner SR. Knowledge, attitudes and perceptions of immigrant parents towards human papillomavirus (HPV) vaccination: A systematic review. Tropical Medicine and Infectious Disease. 2020;5(2):58. doi:10.3390/tropicalmed5020058*
14. *Sinshaw MT, Berhe S, Ayele SG. Knowledge and attitude towards human papillomavirus vaccine and associated factors among mothers who have eligible daughters in Debre Markos Town, Northwest Ethiopia. Infection and Drug Resistance. 2022;Volume 15:781-793. doi:10.2147/idr.s352440*
15. *Awan UA, Naeem W, Khattak AA, et al. An exploratory study of knowledge, attitudes, and practices toward HPV associated anal cancer among Pakistani population. Frontiers in Oncology. 2023;13. doi:10.3389/fonc.2023.1257401*
16. *Alyahya LA, Abu Farha R, Mukattash TL, Mohamed Noor DA. Exploring parental awareness and attitudes towards human papillomavirus infection and vaccination for 9–15-year-old adolescents in Jordan. Journal of Pharmaceutical Health Services Research. 2024;15(2). doi:10.1093/jphsr/rmae007*

Evaluation of attitudes of human papillomavirus vaccine among parents and guardians

Nansalmaa Kh[1], Bayarmagnai L[2], Dashpagam O[3], Oyunbileg D[4], Davaalkham[5]*

[1]Department of Health social work and social sciences, School of Public Health, MNUMS
[2]Department of Epidemiology and Biostatistics, School of Public Health, MNUMS
[3]Immunization Department, National Center for Communicable Diseases of Mongolia
[4]Department for Student Development and Management, MNUMS
[5]School of Public Health, MNUMS
E-mail: nansalmaa.kh@mnums.edu.mn, Tel: +976-99980205

Background: Cervical cancer has a standardized rate of 20.2 cases per 100,000 women and 9.6 deaths per 100,000 women in Mongolia, which is high compared to global and regional levels. The leading cause of cervical cancer is human papillomavirus (HPV) infection, and HPV immunization is the way to prevent infection. The Immunization Law of Mongolia was amended in 2023, and the vaccine against human papillomavirus (HPV) infection was included in the mandatory national scheduled vaccination for 11-year-old children. Attitudes toward HPV infection and the HPV vaccine are essential influences on vaccination decisions. Therefore, there is a need to study the attitude of parents and guardians regarding the newly introduced vaccine and the decision to get vaccinated, which is the basis for conducting this study.
Aim: To assess the attitudes of parents and guardians about the vaccine against human papillomavirus infection.
Materials and Methods: Data were collected using a quantitative research model, and the results were processed in the SPSS 25.0 software. The study involved parents and guardians of children under the age of 15 from 4 aimags, eight sums, and 3 districts of UB city, representing the Mongolian region. Attitudes toward the HPV vaccine were determined by evaluating the importance and effectiveness of the vaccine, agreeing with it, and motivation to get vaccinated.
Results: A total of 3057 parents and guardians participated in the survey; 47.92% were from rural areas, and 52.08% were from Ulaanbaatar. The majority of participants (62.43) are parents and guardians of children aged 9-11 years. 19.85 percent of the respondents believed that their children are at risk of HPV infection, and 37.58 percent agreed that the HPV vaccine is effective in preventing HPV-related cancers. Thirteen percent of parents and guardians said they would vaccinate their children against HPV infection, and 8 in 10 were unsure. When clarifying the reasons for not getting vaccinated against HPV infection, the most common responses were concerns about side effects after vaccination, concerns about the quality and long-term effects of the vaccine. Parents and guardians believe that evidence-based information about the vaccine (48.9 percent) and advice and information from health workers (40.63 percent) are essential when deciding to get vaccinated against HPV infection. Attitudes toward HPV vaccination did not differ by gender, but there were statistically significant differences by location and age.
Conclusion: Providing parents and caregivers with evidence-based information about vaccine safety, side effects, and efficacy, including health professionals, was identified as the most essential and reliable resource for addressing issues that influence HPV vaccine refusal and hesitancy.

Keywords: Immunization, Cervical cancer, Vaccine hesitancy